**МОНГОЛ УЛС**
**ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН**
**ЗАХИРАМЖ**

2024 оны 06 сарын 12 өдөр　　　　Дугаар А/306　　　　Мөрөн сум

Ажлын хэсэг байгуулах,
төлөвлөгөө батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн хэмжээнд 2024-2025 оны хөдөө аж ахуйн салбарын өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангуулах ажлын хэсгийг нэгдүгээр, төв суурин газрын өвөлжилтийн бэлтгэл хангуулах ажлын хэсгийг хоёрдугаар, сумын өвөлжилт, хаваржилтын бэлтгэл ажил хангуулах, удирдлага арга зүйн дэмжлэг үзүүлж ажиллах агентлаг, байгууллагын хуваарийг гуравдугаар, хөдөө аж ахуйн салбарын өвөлжилтийн бэлтгэл хангуулах төлөвлөгөөг дөрөвдүгээр, төв суурин газрын өвөлжилтийн бэлтгэл хангуулах ажлын төлөвлөгөөг тавдугаар хавсралтаар тус, тус баталж хэрэгжүүлж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч, гишүүд, агентлаг байгууллагын удирдлагуудад тус тус үүрэг болгосугай.

2.Аймгийн хэмжээнд өвөлжилт, хаваржилтын бэлтгэл ажлыг зохион байгуулж, явцын мэдээллийг 14 хоногт, нэгдсэн дүнг 2024 оны 11 дүгээр сарын 08 ний өдрийн дотор аймгийн Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулж ажиллахыг ажлын хэсгийн ахлагчид үүрэг болгосугай.

3.Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Б.Батбилгүүн)-т даалгасугай.

ДАРГА　　　　П.ЛХАГВАЖАВ

Захирамж2024
6712010950

Аймгийн Засаг даргын 2024 оны 06
дугаар сарын 12 -ны өдрийн А/206
захирамжийн нэгдүгээр хавсралт

Хөдөө аж ахуйн салбарын өвөлжилтийн бэлтгэл хангуулах
ажлын хэсгийн бүрэлдэхүүн

Ажлын хэсгийн ахлагч: М.Хуягбаатар (Аймгийн Засаг даргын орлогч)

Гишүүд: Б.Оюунтуяа (Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга)

С.Батхуяг (Цэргийн штабын дарга)

С.Ганболд (Онцгой байдлын газрын дарга )

Я.Эрхэмбаяр (Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга)

Л.Ариунаа (Мал эмнэлгийн газрын дарга)

М.Үүрийнбаяр (Эрүүл мэндийн газрын дарга)

Б.Өнөрбат (Ус цаг уур, орчны шинжилгээний төвийн дарга)

Нарийн бичгийн дарга:
Д.Чинзориг (Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн хүнс, хөдөө аж ахуйн бодлого, үйл ажиллагаа хариуцсан мэргэжилтэн)

Аймгийн Засаг даргын 2024 оны 06
дугаар сарын 12 -ны өдрийн А/306
захирамжийн хоёрдугаар хавсралт

Төв суурин газрын өвөлжилтийн бэлтгэл хангуулах
ажлын хэсгийн бүрэлдэхүүн

Ажлын хэсгийн ахлагч: М.Хуягбаатар (Аймгийн Засаг даргын орлогч)

Гишүүд: Б.Оюунтуяа (Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга)

Б.Базар (Санхүү төрийн сангийн хэлтсийн дарга)

С.Ганболд (Онцгой байдлын газрын дарга )

Б.Батбилгүүн (Нийгмийн бодлогын хэлтсийн дарга)

Х.Тайванбаяр (Мөрөн сумын дарга)

Б.Ганзориг (Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын дарга)

Б.Батхүү (“Могойн гол” ХХК захирал)

Б.Галбадрах (“Хөвсгөл –Азза” ХХК захирал)

Ө.Баттулга (Хөвсгөл аймгийн авто тээврийн төвийн дарга)

З.Бадрал (Хөвсгөл-Эрчим хүч ХХК-ийн захирал)

Ц.Цанлигрэнчин (Хөвсгөл дулааны станц ТӨХК-ийн дарга)

Ц.Зоригт (Мөрөн хот тохижилт үйлчилгээний төв ХХК захирал)

Д.Сүхбат (Хөвсгөл-Ус суваг ОНӨК захирал)

Нарийн бичгийн дарга: Д.Сандагдорж (Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дэд бүтцийн бодлого, үйл ажиллагаа зохион байгуулах мэргэжилтэн)

Аймгийн Засаг даргын 2024 оны 06 дугаар сарын 12-ны өдрийн А/306 захирамжийн гуравдугаар хавсралт

СУМДЫН ӨВӨЛЖИЛТИЙН БЭЛТГЭЛИЙГ ХАРИУЦАН ХАНГУУЛАХ АГЕНТЛАГ, БАЙГУУЛЛАГУУДЫН ХУВААРЬ

| № | Сумдын нэрс | Хариуцах хэлтэс, агентлагийн нэр |
|---|---|---|
| 1 | Арбулаг | Төрийн захиргаа удирдлагын хэлтэс |
| 2 | Алаг-Эрдэнэ | Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газар |
| 3 | Баянзүрх | Аймгийн ЗДТГ нийтлэг үйлчилгээний алба |
| 4 | Бүрэнтогтох | Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газар |
| 5 | Галт | “Хөвсгөл Ус суваг” ХХК |
| 6 | Жаргалант | Орон нутгийн өмчийн газар |
| 7 | Их-Уул | Хүнс, хөдөө аж ахуй газар |
| 8 | Рашаант | Эрүүл мэндийн газар |
| 9 | Рэнчинлхүмбэ | Хөвсгөл-Эрчим хүч ХХК |
| 10 | Тариалан | Хүнс хөдөө аж ахуйн газар |
| 11 | Тосонцэнгэл | Нийгмийн бодлогын хэлтэс |
| 12 | Түнэл | Нийгмийн даатгалын хэлтэс |
| 13 | Төмөрбулаг | Ус цаг уур, орчны шинжилгээний төв |
| 14 | Улаан-Уул | Орон нутгийг судлах музей |
| 15 | Цагаан-Уул | Мал эмнэлгийн газар |
| 16 | Цагаан-Үүр | Хууль, эрх зүйн хэлтэс |
| 17 | Цагаан-нуур | Хөвсгөл барилга захиалагчийн хяналтын төв |
| 18 | Цэцэрлэг | Санхүү хяналт дотоод аудитын газар |
| 19 | Чандмань-Өндөр | Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс |
| 20 | Шинэ-Идэр | Статистикийн хэлтэс |
| 21 | Эрдэнэбулган | Хүнс хөдөө аж ахуйн газар |
| 22 | Ханх | Байгаль орчин аялал жуулчлалын газар |
| 23 | Хатгал | Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газар |
| 24 | Мөрөн | Стандарт хэмжил зүйн хэлтэс |

Аймгийн Засаг даргын 2024 оны 06 дугаар сарын .12...-ны өдрийн А/306 захирамжийн дөрөвдүгээр хавсралт

# 2024-2025 ОНД ХӨДӨӨ АЖ АХУЙН САЛБАРЫН ӨВӨЛЖИЛТ, ХАВАРЖИЛТЫН БЭЛТГЭЛ ХАНГАХ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

| № | Хийж хэрэгжүүлэх ажил үйлчилгээ | Хариуцах байгууллага | Хугацаа | Хяналт тавих |
|---|---|---|---|---|
| 1 | 2023-2024 оны өвөлжилтийн бэлтгэл хангах ажлын төлөвлөгөө боловсруулан батлуулах | ХБТХОХ | 6-р сарын 15 | ХБТХОХ |
| 2 | Хүнс, Хөдөө аж ахуйн сайдын 2016 оны А/71 тоот тушаалаар батлагдсан Мал өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах, шалгах, дүгнэх заавар дагуу төлөвлөлт хийж, хэрэгжилтийг ханган ажиллах | Сумдын Засаг дарга ХААТ | 6-10 сард | ХХААГ |
| 3 | Малын тэжээлийн ургамал тариалах чиглэлээр сургалт, мэдээлэл зохион байгуулах | Сумдын Засаг дарга | 6-р сарын 10-25 | ХХААГ |
| 4 | Хаврын тариалалтын мэдээлэл гаргах | ХХААГ | 6-р сарын 10-25 | ХБТХОХ |
| 5 | Өвлийн бэлтгэл хангаж, хашаа саравчаа шинэчлэх засварлах, хөрзөн, өтөг бууцаа бэлтгэсэн малчин өрхийн тоо | Сумдын Засаг дарга | 9-р сарын 15 | ХХААГ |
| 6 | Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний хэлтэс агентлагуудад сумдыг хариуцуулж өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангуулах талаар хамтарч ажиллах | ХБТХОХ | 6-10-р сард | Аймгийн ЗДТГ |
| 7 | Сум, багийн түвшинд мал аж ахуйн өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах төлөвлөгөө гарган хэрэгжүүлэх малчин өрхэд малын тоонд тулгуурлаж бэлтгэх өвс, тэжээлийн даалгавар гардуулж биелэлтийг тооцож ажиллах | -Сум, Багийн Засаг дарга | 8-р сарын 30 | ХХААГ, ХБТХОХ |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 8 | Хадлан тэжээл бэлтгэх техникийн засвар үйлчилгээг эхлүүлж, зохион байгуулалтын арга хэмжээг авч ажиллах | - Сум, багийн Засаг дарга, иргэд | 8 сард | ХХААГ ХБТХОХ |
| 9 | Аймгаас өгсөн өвс тэжээлийн төлөвлөгөөг биелүүлэх орон нутгийн нөөц боломжийг ашиглаж өвс, тэжээлийн илүү их нөөц бүрдүүлэх, зохион байгуулалтын арга хэмжээ авах сум, багийн түвшинд аюулгүйн нөөц бүрдүүлэх | -Сум хариуцсан байгууллагууд, -Сумдын Засаг дарга нар | 8-р сард | ХХААГ ХБТХОХ |
| 10 | Хадлангийн гарц муу сумууд хадлан сайтай сумуудтай хадлан бэлтгүүлэх талаар гэрээ хэлцэл хийх, хамтран ажиллах | -Сумын Засаг дарга | 8 сарын 02 | ХХААГ ХБТХОХ |
| 11 | Мал сүргийг мал эмнэлгийн намрын арга хэмжээнд бүрэн хамруулж тарилга, туулгалт, угаалгыг чанартай зохион байгуулж, хамрагдсан малын тоон мэдээ, тайланг хугацаанд нь ирүүлэх | -Сумын Засаг дарга, МЭҮТ, МЭҮН-үүд | 8-р сарын 25 | Мал эмнэлгийн газар |
| 12 | Баг бүрд бэлчээрийн ургац, даац багтаамжийг тодорхойлох, өвөл хаврын улирлын бэлчээрийн даацыг тодорхойлж танилцуулах | -Сумын засаг дарга, цаг уурын өртөө | 8-р сард | УЦУОШТ |
| 13 | Хадлан тэжээл бэлтгэлийн явцад байнгын хяналт тавих, цаг агаарын урьдчилсан төлөв байдлын мэдээ мэдээллээр хангаж ажиллах | -Сум хариуцсан байгууллагууд Сумын Засаг дарга | 8-9 р сард | ХХААГ УЦУОШТ |
| 14 | Отроор өвөлжих өрх, малын судалгааг нарийвчлан гаргаж отор оруулах сумуудтай гэрээ байгуулах, отроор өвөлжих өрхтэй 2 сумын Засаг даргын гэрээ байгуулах | -Сумын Засаг дарга нар | 9-р сард | Аймгийн ЗДТГ, ХОХБТХ, Хүнс, хөдөө аж ахуйн газар |
| 15 | Отроор өвөлжих малчдын малыг эзэмгжүүлэн, бүртгэл мэдээллийн цахим санд оруулах | Сумын Засаг дарга нар ХААТ | 9-р сард | Хүнс, хөдөө аж ахуйн газар |
| 16 | Орон нутгийн төсвийн болон төсөл хөтөлбөрүүдийн хөрөнгөөр шинээр худаг гаргах, бэлчээрийн хортон мэрэгчтэй тэмцэх ажлын явцад хийх хяналт шалгалтыг сайжруулж ашиглалтад оруулан хүлээж авах | -Сумын ЗДТГ | 8-10 сар | ХХААГ |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 17 | Намрын ургац хураалтын бэлтгэл ажлыг хангах, техник засварын үйлчилгээг хугацаанд гүйцэтгэх | -Сумын Засаг дарга, иргэд, аж ахуйн нэгжүүд | 8-р сард | Хүнс, хөдөө аж ахуйн газар, |
| 18 | Цочир хүйтрэл, их хэмжээний цас, хүчтэй салхи, мөндөр зэрэг цаг агаарын аюултай үзэгдлийн урьдчилсан мэдээ мэдээллээр малчид, тариаланчид, иргэдийг тогтмол хангах | Сумын Засаг дарга, Цаг уурын өртөө | 8-10 сард | УЦУОШТ |
| 19 | Намрын ургац, хураалтыг технологийн дагуу цаг хугацаанд нь гүйцэтгэж, мэдээллийг бодитоор гаргах, цаг хугацаанд мэдээлэх | -Сумдын Засаг дарга, | 8-10-р сард | ХХААГ |
| 20 | Малчин өрх бүр өөрсдийн бололцоогоор өвөлжилтийн бэлтгэл хангаж, малын хашаа хорооны дулаалга, ариутгал халдваргүйтгэлийн арга хэмжээг эртнээс сайтар зохион байгуулах | -Сум, багийн засаг дарга, сумдын Мал эмнэлэг тасаг, Хөдөө аж ахуйн тасаг | 8-10 сард | ХХААГ ХБТХОХ |
| 21 | Орон нутагтаа отроор өвөлжиж, хаваржиж байгаа малчдын талаарх судалгааг үндэслэн эрүүл мэндийн явуулын үйлчилгээ үзүүлэх хуваарь гаргаж ЭМГ-т хүргүүлэх | -Сумын ЗДТГ, ЭМТ | 10-р сараас | Аймгийн эрүүл мэндийн газар |
| 22 | Гадна аймагт болон өөрийн аймгийн бусад сумдад отроор өвөлжих өрхийн малд нэг бүрчлэн үзлэг хийж өрхийн дэвтэр хөтлөх , гоц халдварт өвчний талаар мэдээлэл хийж, зөвлөгөө өгөх | -Сум багийн Засаг дарга, МЭҮТ, МЭҮН-үүд | 8-11 сард | ХХААГ МЭГ |
| 23 | 2024-2025 онд хэрэгцээлэх, зах зээлд борлуулах малыг малын төрөл, сүргийн зохистой харьцаанд тулгуурлан сум, багийн хэмжээнд тоог нэгтгэн судалгаа гаргаж ирүүлэх | -Сум, багийн Засаг дарга, МЭҮТ, МЭҮН-үүд | 9-10 р сард | Хүнс, хөдөө аж ахуйн газар |
| 24 | Хадлан тэжээл бэлтгэх, Ургац хураалтын үед хэрэглэх бензин, дизель түлш, шатах тослох материалын нөөц бүрдүүлэх, хомсдол үүсэхгүй байх тал дээр төлөвлөгөө гарган ажиллах | Сумдын засаг дарга, ШТС-ын эрхлэгч нар | 8-10 сард | ХБТХОХ |
| 25 | Мал хамгаалах санд өвс тэжээлийн тооцоотой сумууд өр авлагаа барагдуулах | -Сумдын Засаг дарга нар | 6-10 сард | ХХААГ ХБТХОХ |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 26 | Цаг үеийн ажлын мэдээ тайланг үнэн бодитоор цаг хугацаанд нь гаргаж ирүүлэх, | -Сум, багийн засаг дарга, Холбогдох албан тушаалтан | 8-10 сард | ХХААГ ХБТХОХ |
| 27 | Аймгийн төвийн хүн амын хаврын улирлын махны нөөцийг бүрдүүлэх арга хэмжээ авах, | Сумдын Засаг дарга нар | 10-11 сард | Аймгийн ЗДТГ, ХОХБТХ ХХААГ |
| 28 | Хаврын тариалалтын бэлтгэл ажлын явц, тариалалтын эцсийн дүн, ургацын урьдчилсан баланс, ургац хураалтын дүнгийн танилцуулгыг холбогдох газарт хүргүүлэн ажиллах | -Сум, багийн засаг дарга, Холбогдох албан тушаалтан | 7-10 сард | Аймгийн ЗДТГ, ХОХБТХ ХХААГ |

-------------------оОо--------------------

АймгийнЗасаг даргын 2024 оны 06 дугаар сарын ...12.......-ны өдрийн А/306 захирамжийн тавдугаар хавсралт

# ТӨВ СУУРИН ГАЗРЫН 2024-2025 ОНЫ ӨВӨЛЖИЛТ, ХАВАРЖИЛТЫН БЭЛТГЭЛ ХАНГАХ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

| № | Хийж хэрэгжүүлэх ажил үйлчилгээ | Хариуцах байгууллага | Хугацаа | Хяналт тавих |
|---|---|---|---|---|
| 1 | Сумдын 35/15/10 КВ-ын ЦДАШ, дэд станцад үзлэг засвар хийх | "Хөвсгөл Эрчим хүч" ХХК | 9 дүгээр сарын 15-ны дотор | ХБТХОХ, ГХБХБГ |
| 2 | Аймгийн хэмжээнд өвлийн их ачаалалд тохируулан тоног төхөөрөмжийн тавил тохируулга хийх | "Хөвсгөл Эрчим хүч" ХХК | 9 дүгээр сарын 15-ны дотор | ХБТХОХ, ГХБХБГ |
| 3 | Өвлийн горим схем тооцоо гаргаж батлуулах | "Хөвсгөл Эрчим хүч" ХХК | 9 дүгээр сарын 15-ны дотор | ХБТХОХ, ГХБХБГ |
| 4 | Аймгийн хэмжээнд аваарын дизель станцын бэлэн байдлыг хангаж, шатаж тослох материалын зохих нөөцийг бүрдүүлэх | "Хөвсгөл Эрчим хүч" ХХК | 9 дүгээр сарын 15-ны дотор | ХБТХОХ, ГХБХБГ |
| 5 | Сумдын дэд станц, дотоод шугам сүлжээний найдвартай хэвийн ажиллагааг хангах, аваарын үед ажиллах горим, бэлэн байдлыг хангах | "Хөвсгөл Эрчим хүч" ХХК | 9 дүгээр сарын 15-ны дотор | ХБТХОХ, ГХБХБГ |
| 6 | ЦДАШ, дэд станц байгууламж, тоног төхөөрөмжийн урсгал засвар, үйлчилгээг графикийн дагуу гүйцэтгэж, найдвартай ажиллагааг бүрэн хангах | "Хөвсгөл Эрчим хүч" ХХК | 9 дүгээр сарын 15-ны дотор | ХБТХОХ, ГХБХБГ |
| 7 | Байгууллагынхаа өвөлжилтийн бэлтгэл ажлыг бүрэн хангаж ажиллах хүч, техник тоног төхөөрөмжийн найдвартай ажиллагааг хангах | "Хөвсгөл Эрчим хүч" ХХК | 9 дүгээр сарын 15-ны дотор | ХБТХОХ, ГХБХБГ |
| 8 | Шаардлагатай тохиолдолд ашиглах нөөц дизелийн бэлэн байдлыг хангаж ажиллах | Хөвсгөл Эрчим хүч" ХХК Сумдын ЗДТГ | 9 дүгээр сарын 15-ны дотор | ХБТХОХ, ГХБХБГ |
| | Дулааны станцын 2024-2025 оны өвөлжилтийн бэлтгэл хангах ажлын хүрээнд 20-оос доошгүй хоногийн нүүрс нөөцлөх хуваарь гарган бүрдүүлэх, нүүрс | "Хөвсгөл дулааны станц" ТӨХК | 9 дүгээр сарын 15-ны дотор | ХБТХОХ, ГХБХБГ |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 9 | тээвэрлэлтийг тасралтгүй, найдвартай зохион байгуулах, аваар ослын үед хэрэглэх техник тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгслийн нөөц бүрдүүлэх | | | |
| 10 | Байгууллагынхаа өвөлжилтийн бэлтгэл ажлыг бүрэн хангаж, ажиллах хүч, техник, тоног төхөөрөмжийн бэлэн байдлыг хангах | “Хөвсгөл дулааны станц” ТӨХК | 9 дүгээр сарын 15-ны дотор | ХБТХОХ, ГХБХБГ |
| 11 | Хэрэглэгч ААН, байгууллага, иргэдтэй өр авлагыг бүрэн барагдуулах | “Хөвсгөл дулааны станц” ТӨХК | 9 дүгээр сарын 15-ны дотор | ХБТХОХ, ГХБХБГ |
| 12 | Зуухны засвар үйлчилгээг хийлгэж ашиглалтад бэлэн байлгах | “Хөвсгөл дулааны станц” ТӨХК | 9 дүгээр сарын 15-ны дотор | ХБТХОХ, ГХБХБГ |
| 13 | Энэ оны Могойн голын олборлолтоос өөрмдлөгийн дээж авч мэргэжлийн байгууллагын лабораторид шинжилгээ хийлгэх | “Хөвсгөл дулааны станц” ТӨХК | 9 дүгээр сарын 15-ны дотор | ХБТХОХ, ГХБХБГ |
| 14 | Хот, сум хоорондын зорчигч тээврийн үйлчилгээний найдвартай, аюулгүйн ажиллагаа, диспетчерийн хяналтын шуурхай ажиллагааг хангах | Аймгийн авто тээврийн төв | 9 дүгээр сарын 15-ны дотор | ХБТХОХ, ГХБХБГ |
| 15 | Зорчигч тээврийн автомашины /тоо/ бүрэн бүтэн, техникийн аюулгүй ажиллагааг хангаж, жолоочийн үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэх | Аймгийн авто тээврийн төв | 9 дүгээр сарын 15-ны дотор | ХБТХОХ, ГХБХБГ |
| 16 | Авто тээврийн төвийнхөө өвөлжилтийн бэлтгэл ажлыг бүрэн хангаж ажиллах | Аймгийн авто тээврийн төв | 9 дүгээр сарын 15-ны дотор | ХБТХОХ, ГХБХБГ |
| 17 | Авто зам засвар арчилгаа ашиглагчийн бүх төрлийн техник тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээг чанартай хийж гүйцэтгэх, найдвартай ажиллагааг хангах | “Хөвсгөл АЗЗА” ТӨХК | 9 дүгээр сарын 15-ны дотор | ХБТХОХ, ГХБХБГ |
| 18 | Зам засвар арчлалт, зам даваа хаагдсан үед шуурхай зохион байгуулалттай ажиллаа, хүн хүч, техникийн нөөц бүрдүүлэх | “Хөвсгөл АЗЗА” ТӨХК | 9 дүгээр сарын 15-ны дотор | ХБТХОХ, ГХБХБГ |
| 19 | Аймгийн хэмжээнд болон сум суурин газрын халуун ус, цэвэр, бохир, ариутгах татуурга, худаг усан сангийн засвар, дулаалга, | “Хөвсгөл ус суваг” ХХК, | 9 дүгээр сарын 15-ны дотор | ХБТХОХ, ГХБХБГ |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 20 | инженерийн шугам сүлжээний засвар шинэчлэлтийн ажлыг дулааны улиралд бүрэн хийж гүйцэтгэх | Сумдын ЗДТГ, ААНБ | | |
| 20 | Өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах шаардлагатай тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн нөөц бүрдүүлэх | "Хөвсгөл ус суваг" ХХК, Сумдын ЗДТГ, ААНБ | 9 дүгээр сарын 15-ны дотор | ХБТХОХ, ГХБХБГ |
| 21 | Хүн хүч, техник тоног төхөөрөмжийн найдвартай хэвийн ажиллагааг хангаж, урсгал болон их засварыг чанартай хийж гүйцэтгэх | "Хөвсгөл ус суваг" ХХК | 9 дүгээр сарын 15-ны дотор | ХБТХОХ, ГХБХБГ |
| 22 | Байгууллагынхаа өвөлжилтийн бэлтгэл ажлыг бүрэн хангаж, аваарын үед ажиллах горимыг баталж мөрдөх | "Хөвсгөл ус суваг" ХХК, Сумдын ЗДТГ, ААНБ | 9 дүгээр сарын 15-ны дотор | ХБТХОХ, ГХБХБГ |
| 23 | Машин, техник тоног төхөөрөмж, техник хэрэгслийн графикт болон урсгал засвар, шинэчлэлтийг чанартай хийж хэвийн найдвартай ажиллагааг хангах | Аймгийн холбооны газар, Мэдээлэл холбоо сүлжээ ХХК, Шуудан үйлчилгээний газар, РӨНС | 9 дүгээр сарын 15-ны дотор | ХБТХОХ, ГХБХБГ |
| 24 | Сумдын харилцаа холбооны салбарын өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангуулж, үйл ажиллагаа нь тасралтгүй явуулах нөхцөл бүрдүүлэх | Аймгийн холбооны газар, Мэдээлэл холбоо сүлжээ ХХК, Шуудан үйлчилгээний газар, РӨНС | Өдөр тутам | ХБТХОХ, ГХБХБГ |
| 25 | Барилга байгууламж, инженерийн шугам сүлжээ, тоног төхөөрөмжийн урсгал засварын ажил, Боловсрол, соёл, эрүүл мэнд, спортын байгууллагуудын барилгын засварын ажлыг хугацаанд нь чанартай хийж дуусгах ажлыг шуурхай зохион байгуулж, биелэлтэд нь хяналт тавьж ажиллах | Сумдын Засаг дарга, ГХБХБГ, ОНӨГазар | Гэрээний дагуу | ХБТХОХ, ГХБХБГ |
| 26 | Үйлдвэрийн найдвартай ажиллагааг хангах, дизелийн түлш шатахууны нөөц бүрдүүлэн уурхайн хөрс хуулалт, их засварын ажлыг хугацаанд нь хийж, нүүрсний бэлэн нөөцийг хэвийн хэмжээнд байлгах, аваар ослын үед хэрэглэх техник тоног төхөөрөмж, сэлбэг | "Могойн гол" ХХК, Жилчиг булаг нүүрсний уурхай | 9 дүгээр сарын 15-ны дотор | ХБТХОХ, ГХБХБГ |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | хэрэгслийн нөөц бүрдүүлэх талаар холбогдох арга хэмжээ авч ажиллах | | | |
| 27 | Төв суурин газрын айл өрх, албан байгууллагын дулаан хангамжийг шийдвэрлэх хүрээнд Могойн голын сайн чанарын нүүрсээр хангах ажлыг зохион байгуулах, нүүрс худалдаалах цэг, салбарыг бий болгох | “Могойн гол” ХХК, | 09 дугаар сарын 30-ны дотор | ХБТХОХ |
| 28 | Аймгийн төв болон бусад суурин газруудын дулааны станц, халаалтын уурын зуухны тоног төхөөрөмж, шугам сүлжээний засвар үйлчилгээг тогтоосон хугацаанд хийж бэлэн байдлыг хангуулах, нүүрсний аюулгүйн нөөц бүрдүүлэх ажлыг 2024 оны 9 дүгээр сарын 10-ний өдрийн дотор дуусгах | Сумдын Засаг дарга, ААНБ, айл өрх, иргэн бүр | 9 дүгээр сарын 15-ны дотор | ХБТХОХ, ГХБХБГ |

--------------------oOo--------------------